



**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

271.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1218
272.	Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1219
273.	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1224
274.	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1225
275.	Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1226
276.	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1228

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

277.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 49	1228
278.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 50	1229

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

279.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 104	1229
280.	Шүүхийн Ёс зүйн хорооны даргыг томилох тухай	Дугаар 105	1230

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

281.	Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 152	1230
------	---	------------	------



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт:**

“24.1.5.шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох.”

#### **2/36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсэг:**

“36.11.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гадаад улсад авсан иргэн Монгол Улсад уг үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой харилцааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:**

“24.2.Хуульч нь энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байна.”

#### **2/35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг:**

“35.1.Өмгөөлөгч энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд дараах хэлбэрийн үйлчилгээг үзүүлнэ:”

#### **3/36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг:**

“36.1.Хуульч нь энэ хуулийн 24.1-д заасан мэргэжлийн үйл ажиллагааг ганцаарчлан, гэрээгээр хамтарч, түүнчлэн хуулийн этгээд байгуулан эрхэлж болно.”

#### **4/36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэг:**

“36.3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх



хуулийн этгээд /цаашид “өмгөөллийн хуулийн этгээд” гэх/-ийн хэлбэр нь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байна.”

**3 дугаар зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн гарчгийн “Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх” гэснийг “Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1 дэх хэсгийн “цалинтай” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нөхөрлөлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах бүлэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:**

“3/хязгаарлагдмал хариуцлагатай.”

**2/10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:**

“5/хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хувьд нөхөрлөлийн гишүүдэд эрх бүхий байгууллагаас олгосон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн баримт бичиг.”

**3/Дөрөвдүгээр бүлэг:**

**“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл**

**29 дүгээр зүйл.**Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

1.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл



ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна.

2.Хуульд хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар зааснаас бусад тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх эрх бүхий иргэн хуулийн этгээдийн бусад хэлбэрээс аль тохирохыг сонгож болно.

3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх нөхөрлөл энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэртэй байна.

4.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах замаар Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

5.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нэрийн ард “ХХН” гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

6.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь мэргэжлийн үйл ажиллагааг илэрхийлэх өөрийн бэлгэдэл, таних тэмдэгтэй байж болно.

### **30 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байгуулах, бүртгүүлэх**

1.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1-д заасан гэрээний үндсэн дээр байгуулах бөгөөд гэрээнд доор дурдсан зүйлийг тусгана:

1/нөхөрлөлийн оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

2/эрхлэх үйл ажиллагаа;

3/нөхөрлөлийн гишүүний тоо, гишүүний овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний харьяалал, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг;

4/удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүний овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, регистрийн дугаар;

5/гишүүн тус бүрийн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээ, үнэлгээ, үнэлэх аргачлал, буцаан олгох нөхцөл болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;



6/мэргэжлийн үйл ажиллагааны чадвараа нэгтгэж байгаа бол түүний үнэлгээ, үнэлэх аргачлал, үзүүлэх үйлчилгээ;

7/шийдвэр гаргах арга, журам;

8/ашиг хуваарилах зарчим;

9/их хэмжээний үнийн дүнтэй болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлох журам;

10/гэрээ байгуулсан он, сар, өдөр;

11/шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

2.Нөхөрлөлд шинээр гишүүн орох, эсхүл нөхөрлөлөөс гарах, чөлөөлөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах ба энэ тухай хуулийн этгээдийг бүртгэх эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ.

3.Нөхөрлөлийн гишүүний нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон мэргэжлийн үйл ажиллагааны чадвар, түүний үнэлгээний талаар маргаан үүсвэл үнэлгээг хөндлөнгийн шинжээч зах зээлийн жишгээр тодорхойлно. Хөндлөнгийн шинжээчийг талууд харилцан тохиролцож томилно.

4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол ашиг хуваарилахдаа гишүүдийн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, тэдгээрийн тухайн жилийн мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан тооцно.

### **31 дүгээр зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн удирдлага, хяналт**

1.Нөхөрлөлийн эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

2.Бүх гишүүдийн хуралд нөхөрлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор тухайн хурал хүчинтэйд тооцогдох бөгөөд хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

1/гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/нөхөрлөлийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх;

3/нөхөрлөлийг татан буулгах;

4/нөхөрлөлийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;

5/их хэмжээний үнийн дүнтэй болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрөх эсэх;

6/нөхөрлөл гүйцэтгэх удирдлагатай байх эсэх, хэрэв гүйцэтгэх удирдлагын бүтэцтэй бол түүний бүрэн эрх, үүрэг хариуцлагын журам, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;



7/гишүүдэд хуваарилах ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах журмыг батлах;

8/нөхөрлөлд шинэ гишүүн орох, нөхөрлөлөөс гарах, чөлөөлөх;

9/гүйцэтгэх удирдлага болон гишүүний саналаар хэлэлцүүлэх бусад асуудал.

3.Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлын шийдвэрийг бүх гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна.

### **32 дугаар зүйл.Нөхөрлөлийн гишүүний эрх, үүрэг**

1.Нөхөрлөлийн гишүүн нь эрх, үүргээ нөхөрлөлийн ашиг сонирхолд нийцүүлэн шударгаар хэрэгжүүлнэ.

2.Нөхөрлөлийн гишүүн нь мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэхээр хөрөнгө, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа нэгтгэн нөхөрлөлд оруулах бөгөөд нөхөрлөлийн гишүүний эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаагаа биечлэн гүйцэтгэнэ.

3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөлийн гишүүн тус бүр тэнцүү тооны саналын эрхтэй байна.

4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн аль ч гишүүн нөхөрлөлийг төлөөлж болно.

5.Нөхөрлөлийн гишүүн нь багшлах, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн төрийн бус байгууллагад хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэх, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

6.Үйлчлүүлэгч хүсэлт гаргавал нөхөрлөл болон нөхөрлөлийн гишүүн өөрийн хариуцлага хүлээх чадварын талаар үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

### **33 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл ба гишүүдийн хариуцлага**

1.Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ өөрийн хөрөнгөөр хариуцна. Нөхөрлөлийн гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгөөрөө хязгаарлагдмал хариуцлага хүлээнэ.



2.Доор дурдсан тохиолдолд дараах этгээд дангаараа болон хэсгээр хамтарч хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ:

1/буруутай үйл ажиллагаа явуулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол нөхөрлөлийн гишүүн;

2/буруутай үйл ажиллагаа явуулсан нөхөрлөлийн гишүүний болон бусад этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй гишүүн, эсхүл буруутай үйл ажиллагаа явуулсныг мэдсэн, мэдэх ёстой байсан боловч шаардлагатай арга хэмжээ аваагүй гишүүн.

3.Нөхөрлөлийн гишүүний бусдад учруулсан хохирлыг нөхөрлөлийн хөрөнгөөр тэргүүн ээлжинд барагдуулна. Хохирлыг барагдуулахад нөхөрлөлийн хөрөнгө хүрэлцэхгүй бол энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөх хариуцлага хүлээнэ.

#### **34 дүгээр зүйл.Нөхөрлөлд гишүүн орох, нөхөрлөлөөс гарах, чөлөөлөх**

1.Хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд нөхөрлөлд шинээр гишүүн орж болох бөгөөд нөхөрлөлийн хүлээсэн үүргийг бусад гишүүний нэгэн адил хариуцна.

2.Нөхөрлөлийн гишүүнийг бүх гишүүдийн хурлын олонхын саналаар чөлөөлж болно.

3.Нөхөрлөлийн гишүүнийг доор дурдсан үндэслэлээр чөлөөлнө:

1/гэрээгээр хүлээсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлэх чадваргүй, эсхүл хөрөнгө оруулах боломжгүй нь тогтоогдсон;

2/гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн;

3/гэрээнд заасан бусад нөхцөл.

4.Нөхөрлөлийн гишүүнээс чөлөөлөх үндэслэлийг тухайн гишүүнд урьдчилан мэдэгдэх бөгөөд чөлөөлөх асуудлыг гишүүд хэлэлцэж шийдвэрлэхэд уг гишүүн оролцож тайлбар гаргах эрхтэй. Нөхөрлөлийн гишүүнээс чөлөөлсөн шийдвэрийг тухайн гишүүнд мэдэгдэнэ.

5.Нөхөрлөлөөс чөлөөлөгдсөн гишүүн уг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

6.Нөхөрлөлийн гишүүн бусад гишүүддээ 30 хоногийн өмнө мэдэгдсэнээр нөхөрлөлөөс гарч болно.



7.Нөхөрлөлийн гишүүний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсноор нөхөрлөлийн гишүүний эрхээ алдсанд тооцно.

8.Энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 6, 7 дахь хэсэгт заасны дагуу нөхөрлөлөөс гарсан, чөлөөлөгдсөн нөхөрлөлийн гишүүний эрхээ алдсан тохиолдолд тухайн гишүүнд хуваарилах хөрөнгө, ашиг, үйлчлүүлэгчийн мэдээлэл зэргийг энэ хуулийн 30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг баримталж, мөн алдагдлыг энэ хуулийн 33 дугаар зүйлд заасныг баримтлан тус тус шийдвэрлэж хуваарилна.

9.Гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөрлөлийн гишүүний эрхээ алдсан, нөхөрлөлөөс гарсан, чөлөөлөгдсөн гишүүний нөхөрлөлд оруулсан хөрөнгийг гарсан өдрөөс хойш гурван сарын дотор буцаан олгоно.”

**2 дугаар зүйл.**Нөхөрлөлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“2/нэг ч гишүүн үлдээгүй, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хувьд хоёроос доош гишүүн үлдсэн;”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.1.татварын тухай хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан мэргэжлийн туслалцаа үзүүлэх, сурталчлан таниулах;”





**2 дугаар зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бодогч, татварын итгэмжлэгдсэн эрх зүйчийг” гэснийг “бодогчийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “тав” гэснийг “гурав” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “, татварын итгэмжлэгдсэн эрх зүйч” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “, татварын итгэмжлэгдсэн эрх зүйч нь эрх зүйч” гэснийг, 15.1.2 дахь заалтын “, эрх зүйч” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ойн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/26 дугаар зүйлийн 26.2, 26.3 дахь хэсэг:**

“26.2.Түймрийн аюултай үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ой, хээрийн бүс нутагт дараах үйлдэл хийхийг хориглоно:

26.2.1.өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлэх;

26.2.2.мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэх;

26.2.3.шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн болон бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаях;

26.2.4.тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог, хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашиглах.

26.3.Ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм нормативын дагуу бүрдүүлэх ба тэдгээрийг түймэр гарсан үед ашиглахад бэлэн байлгана.

#### **2/39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэг:**

“39.10.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд зохих журмын дагуу урамшуулал олгоно.”

#### **3/47 дугаар зүйлийн 47.2.15 дахь заалт:**

“47.2.15.энэ хуулийн 26.2, 26.3-т заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг



сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох.”

**2 дугаар зүйл.**Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “нэгж дэх” гэсний дараа “, эсхүл эзэмшлийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалтын эхэнд “ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод үржүүлэх ажил эрхлэн” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.13 дахь заалтын “зөвшөөрөл авч” гэсний дараа “байгаль хамгаалагчид мэдэгдэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Ойн тухай хуулийн доор дурдсан хэсэг, заалтыг өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:**

“3.1.13.”ойн тооллого, ой зохион байгуулалт” гэж ойн сангийн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, хүлэмжийн хийн шингээлтийг тооцох, биомассын судалгаа хийх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон үйл ажиллагааг;”

**2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:**

“7.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойн тооллогыг таван жил тутам улсын хэмжээнд явуулж, ойн сангийн төлөв байдлыг шинэчлэн тогтооно. Ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд хийж, ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэчлэн батална.”

**3/34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг:**

“34.5.Энэ хуулийн 34.1-д заасан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**4/42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг:**

“42.2.Энэ хуулийн 42.1-д заасан шууд хохирол болон ойг нөхөн сэргээхэд шаардагдах зардлын нөхөн төлбөрийг байгаль орчны хяналтын улсын байцаагч ногдуулж, төлөлтөд хяналт тавина.”

**4 дүгээр зүйл.**Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Ой зохион байгуулалт” гэснийг “Ойн тооллого, ой зохион байгуулалт” гэж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “Ой зохион байгуулалтын” гэснийг “Ойн тооллого, ой зохион байгуулалтын” гэж, 7.4



дэх хэсгийн “Ой зохион байгуулалтыг” гэснийг “Ойн тооллого, ой зохион байгуулалтыг” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, 28.4, 38.1 дэх хэсгийн хаалтан доторх “байхгүй бол сум дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ гэснийг “байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч” гэж, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийн “энэ хуулийн 39.2-39.4-т” гэснийг “энэ хуулийн 39.2-39.4, 39.10-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

#### **ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

#### **Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Улсын Их Хурлын гишүүн Санжаасүрэнгийн Оюуныг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Өргөдлийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

#### **Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2013 оны 07 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 104

Улаанбаатар  
хот

#### **Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.7, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Дадалын Завудыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Нацагдоржийн Баяраг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2013 оны 07 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 105

Улаанбаатар  
хот

### **Шүүхийн Ёс зүйн хорооны даргыг томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Оюунсайханы Алтангэрэлийг Шүүхийн Ёс зүйн хорооны даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар  
хот

### **Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг эрчимжүүлэх, Монгол Улсын далайд гарах боломжийг нэмэгдүүлэх, экспорт, импортын бараа эргэлтийг хурдасгах зорилгоор Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1.2.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай 2009 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд “Дунзяны гаалийн баталгаат боомт” бүсэд Хятадын талтай хамтарсан тээвэр ложистикийн



төсөл хэрэгжүүлэх Монголын талын төлөөллөөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийг давуу эрхээр оролцуулах, тухайн төсөлд хөрөнгө оруулах чадамжтай хувийн хэвшлийн төлөөллийг сонгож оролцуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвад даалгасугай.

2. БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай шинэ дүүргийн “Дунзяны гаалийн баталгаат боомт” бүсэд 50 жилийн хугацаагаар 10 га газрыг Хятадын талтай хамтарч эзэмшиж ашиглах эрх авахад монголын талаас гаргах хөрөнгийг Монголбанк болон Зам, тээврийн яамны хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөн хэрэглээний барааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай.

3. Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээр болон далайд гарцгүй улсын статусаа ашиглан Тяньжин боомт хүртэл далайгаар дамжин Монгол Улсад ирж байгаа ачаа тээврийн үнэ тарифыг бууруулах талаар судалгаа хийж, холбогдох арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгасугай.

4. Монгол Улсын хилийн боомтууд болон БНХАУ-ын Тяньжин боомтын хооронд төмөр зам болон авто замын нэвтрүүлэх хүчин чадал, тээврийн тарифын асуудал, дамжин өнгөрөх барааг тээвэрлэхэд далайд гарцгүй улсын тээврийн хэрэгслийг ашиглах боломж болон хэлбэрийн талаар хятадын талтай хэлэлцээ хийж, үр дүнг Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанд танилцуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд А.Гансүхэд даалгасугай.

5. БНХАУ-ын Тяньжин боомтод хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын экспорт, импортын барааны эргэлтийг хурдасгах, тээвэр ложистикийн төслийг хэрэгжүүлэх, цаашид хөдөө аж ахуй, уул уурхайн болон газрын тосны бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх, хадгалах, борлуулах төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2013-2016 онд хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь зохион байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг “Улаанбаатарын төлөөлөгчийн газар”-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвад даалгасугай.

6. БНХАУ-ын Тяньжин боомтод хөдөө аж ахуй, уул уурхайн болон газрын тосны бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх, хадгалах, далайн баялаг ашиглах, борлуулах, үйлдвэрлэл явуулахад шаардагдах 200 хүртэл га газрыг хятадын талтай хамтарч эзэмшиж ашиглах эрх авахад монголын талаас гаргах хөрөнгийн эх үүсвэрийг 2014-2016 оны улсын төсөвт тусгаж, Хөгжлийн банкнаас хэрэгжүүлж төсөлд хамруулах, хувийн хэвшлийн



хөрөнгө оруулалтыг татан оролцуулах хэлбэрээр санхүүжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Д.ТЭРБИШДАГВА**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1

**Индекс: 14003**